

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа

Отгонбаяр Д., Даицэрэн Б., Лхамдулам Б., Энхзул Т., Баасанжав Н.

²”Ач” Анагаах ухааны их сургууль

otgonbayar.d@ach.edu.mn

Abstract

A study of factors affecting the implementation of the curriculum

Otgonbayar D., Dashtseren B., Lkhamdulam B., Enkhzul T., Baasanjav N.

²”Ach” Medical University

otgonbayar.d@ach.edu.mn

Introduction

The curriculum development is important issue, especially stakeholder’s evaluations for the implementation of the curriculum. Accordingly, this time we conducted this survey to determine the level of satisfaction of teachers, which is a key factor in implementation of curriculum at the “Ach” Medical University.

Goal

To study curriculum implementation assessment by teachers at the Ach Medical University.

Materials and Methods

Study was conducted descriptive study design using quantitative research methodology. The Likert scale (1-5) used for the assessment of satisfaction score. Total 77 teachers were included in the study. Study questionnaire included 7 groups with 53 questionnaires.

Results

Total n=77 teachers included in the study. The satisfaction level of teachers for the implementation of curriculum was 73% (n=56) satisfied with satisfaction, 22% moderate satisfaction (n=17), and medium satisfaction teacher 5% (n=4).

The satisfaction level of teacher workload and job satisfaction is high enough to satisfy the workload of the trainee, the time to prepare the lesson, and the opportunity to work with the students in the classroom. 3.6-4.2, while the teacher’s work value or salary the level of satisfaction level is 3.11, the minimum value is 2.75, the average.

Conclusion: The average satisfaction score was 4.11 above the average but the effectiveness of the program, the effectiveness of the teacher’s work, study environment and textbooks were below average.

Key words: Curriculum, teacher, satisfaction, implementation, assessment

Pp. 75-79 , Tables 6, Figures 2, References 6

Үндэслэл

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн тогтолцоо үндсээрээ өөрчлөгдөж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэлээ болгон хуулинд өөрчлөлт хийгдсэн. Эрүүл мэндийн салбарын бодлого өөрчлөгдсөнтэй холбоотойгоор эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэдэг анагаахын сургуулиудын сургалтын бодлого мөн өөрчлөгдөж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхдагч шатлалд ажиллах чадвартай, эмч эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх бодлого дэлхий нийтийн хандлага болсон. Улс

орны анагаахын сургуулиудын суралцах жил, судлах хичээл ойролцоо боловч төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага, мэргэжилтэнд тавигдах шаардлага зөрүүтэй байна. Дэлхийн анагаах ухааны боловсролын холбоо болон эрдэмтэн судлаачид дүгнэн, энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Дэлхийн анагаахын боловсролд тавигдах тулгуур шаардлага”, Номхон далайн баруун эргийн бүсийн анагаахын сургуулиудын “Боловсролын чанарын баталгаа” стандарт, зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлж байна. Ийм ч учраас өнөөдөр аль улсад, ямар сургууль төгсөж мэргэжил эзэмшсэнээс хамаарахгүйгээр хаана ч очиж ажиллах чадвартай эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэдэг болоход анагаах

ухааны сургуулиуд үндэсний, бүс нутгийн, дэлхийн түвшинд хамтран ажиллах боллоо. Анагаахын сургуулиуд мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд оролцогч талуудын үнэлгээг судалгаанд суурилан хийж, сургалтын хөтөлбөрөө хөгжүүлэх нь олон талын ач холбогдолтой тул бид энэ удаа “Ач” АУИС-ийн мэргэжлийн салбаруудын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч гол хүчин зүйл болох багш нарын сэтгэл ханамжийн түвшинг тогтоох зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

Түлхүүр үг: Сургалтын хөтөлбөр, багш, сэтгэл ханамж, хэрэгжилт, үнэлгээ,

Зорилго: “Ач” АУИС-ийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн багш нарын үнэлгээг судлан тогтоох

Зорилт:

1. “Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын бүрэлдэхүүн, бүтцийг судлах
2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд өгсөн багш нарын үнэлгээ болон сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судлах

Хэрэглэгдэхүүн, арга зүй

Судалгаагнэгэн агшны дискриптив загвараар тоон судалгааны аргыг ашиглан “Ач” АУИС-ийн Анагаах ухааны салбарын ангид хичээл

заадаг (n=53), Уламжлалт анагаах ухааны салбарт хичээл заадаг (n=36), Нүүр ам судлалын салбарын ангид хичээл заадаг (n=40), Сувилахуйн салбарын ангид хичээл заадаг (n=30) /давтагдсан тоогоор/ нийт 77 багшийг судалгаанд хамруулан нийт 7бүлэг 53 асуулт бүхий судалгааны асуумж хуудсаар санал нийлэхээс эс нийлэх хүртэл Ликертийн хэмжүүрээр 1-5 оноогоор сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлов.

Судалгааны ажлын үр дүнгийн хүснэгт, дүрслэлийг Microsoft Office иж бүрдэл, Статистик боловсруулалтыг SPSS-17 программыг ашиглан гүйцэтгэж, хувь болон дундаж утгын статистик магадлал бүхий ялгааг 95 хувийн магадлалаар баталгаажуулав.

Үр дүн

Судалгаанд хамрагдсан багш нарын насны бүлэг, хүйсийн харьцаасургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд өгсөн сэтгэл ханамжийн талаарх үр дүнг дараах зураг хүснэгтүүдээр харуулав. Судалгаанд нийт n=77 багш хамрагдсанаас эрэгтэй (n=27), эмэгтэй (n=50) багш байлаа. Нийт судалгаанд хамрагдсан багш нарын насны бүлгийг судалж үзэхэд 30 аас доош насны 16 (21%), 31-40 насны 26 (34%), 41-49 насны 18 (23%), 50-аас дээш насны 17 (22%) багш судалгаанд хамрагдав (Хүснэгт 1).

Table 1. Age group and gender of participant's survey

Age	Total		Men		Women	
	n	%	n	%	n	%
below 30 age	16	20,78	4	14,8	12	24
31-40 age	26	33,77	7	25,93	19	38
41-49 age	18	23,38	4	14,81	14	28
Up to 50 age	17	22,08	12	44,44	5	10

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа багш нарын албан тушаалын зэрэглэлийн судлаж үзэхэд гэрээт багш 23,3% (n=18), дадлагажигч багш 10,3% (n=8), багш 29,87% (n=23), ахлах

багш 22,07 % (n=17), дэд профессор 3,8% (n=3), профессор 10,3% (n=8) байгаа бөгөөд нас ахих тусам албан тушаалын зэрэглэл өсөж байгаа зүй тогтол ажиглагдлаа (P<0.05) (Хүснэгт 2).

Table 2. Position of participant's survey

Position	Total		Men		Women		P value
	n	%	n	%	n	%	
Part-time lecturer	18	23,3	5	19,2	13	25,4	0,00015
Practitioner	8	10,3	3	11,5	5	9,8	
Lecturer	23	29,8	4	15,4	19	37,2	
Senior lecturer	17	22,0	6	23,1	11	21,5	
Associate Professor	3	3,9	0	0,0	3	5,8	
Professor	8	10,3	8	30,8	0	0,0	

Багш нарын ажилласан жилийг судлаж үзэхэд 0-5 жил ажиллаж байгаа багш 27% (n=21), 6-10 жил ажиллаж байгаа багш 22,08% (n=17), 11-15

жил ажилласан багш 10,39% (n=8), 16-20 жил ажилласан багш 19,48% (n=15), 20-с дээш жил ажилласан 20,78% (n=16) байна (Хүснэгт 3).

Table 3. Employed year of lecturer

Employed year	n	%
0-5 years	21	27,27
6-10years	17	22,08
11-15years	8	10,39
16-20years	15	19,48
Up to 20years	16	20,78

Сургалтын хөтөлбөрт хичээл зааж байгаа багш нарын зааж байгаа салбар шинжлэх ухааны

чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн байдлыг дараах зургаар илэрхийлэв (Зураг 1).




Figure 1. Teachers' field profession

Судалгаанд хамрагдсан багш нарын үндсэн мэргэжлийн чиглэлээр буюу өөрсдийн зааж буй хичээлийн чиглэлээр үндсэн мэргэшил эзэмшсэн байдлыг судлаж үзэхэд дийлэнх нь буюу 68% хувь (n=52) нь үндсэн нарийн

мэргэжил эзэмшсэн, 12% нь буюу (n=9) нь нарийн мэргэшээгүй, 16% нь буюу (n=15) багш өөр мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байна (Зураг 2).




Figure 2. Satisfaction of lecturer

“Ач” АУИС-ийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд оролцож багшлахдаа хэр сэтгэл ханамжтай байдаг талаар судлаж үзэхэд судалгаанд хамрагдсан багш нарын 73% буюу (n= 56) сэтгэл ханамжтай, сэтгэл ханамж дунд зэрэг 22% (n= 17) багш, дунджаас доогуур сэтгэл ханамжтай багш 5% буюу (n= 4) байлаа (Зураг 2).

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд өгсөн багш нарын сэтгэл ханамж албан тушаалын зэрэглэлээс хамаарч ялгаатай байгаа эсэхийг судлаж үзэхэд статистикийн хувьд ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй нийт багш нарын сэтгэл ханамжийн түвшин дээд утга нь 4.55, доод утга нь 3.68, дундаж сэтгэл ханамжийн түвшин 4.11 байлаа (Хүснэгт 4).

Table 4. Teacher's satisfaction and position

	n	Mean	Std deviation	Std error	Max	Min
Part-time lecturer	18	4,22	0,6	0,29	4,51	3,93
Practitioner	8	3,88	0,6	0,415	4,29	3,46
Lecturer	22	3,77	0,8	0,35	4,13	3,42
Senior lecturer	17	3,76	1,1	0,53	4,29	3,24
Associate Professor	3	4,67	0,5	0,53	5,20	4,13
Professor	8	4,38	0,7	0,48	4,86	3,89
Total		4,11	0,7	0,43	4,55	3,68

Судалгаанд хамрагдсан багш нараас багшийн ажлын ачаалал болон ажлын үнэлэмжийн талаар сэтгэл ханамжийн түвшинг судлаж үзэхэд сургалтаар гүйцэтгэж байгаа ачаалаал, хичээлд бэлтгэх цаг хугацаа, танхимын бус сургалтаар оюутантай ажиллах боломж нөхцөлд сэтгэл

ханамжийн түвшин хангалттай буюу 3.6-4.2, харин багшийн ажлын үнэлэмж буюу цалин хөлсний хувьд судалгаанд хамрагдсан нийт багш нарын сэтгэл ханамжийн түвшин дээд утга нь 3.11, доод утга нь 2.75, дундаж сэтгэл ханамжийн түвшин 2.9 байлаа (Хүснэгт 5).

Table 5. Teacher workload and level of satisfaction

Indicator	n	Mean	Std deviation	Std error	Max 95% CI*	Min 95% CI*
The training load is appropriate	77	4,10	0,88	0,20	4,30	3,91
The time required to prepare for the course is sufficient	77	4,21	0,92	0,20	4,41	4,00
Time for students to spend on non-classroom training	77	3,60	1,02	0,23	3,83	3,37
Salary and value of lecturer work	77	2,9	0,65	0,25	3,11	2,75

Судалгаанд хамрагдсан багш нараас сургалтын хөтөлбөрийн орчин нөхцөлд хэр сэтгэл ханамжтай байгааг тодруулахад дадлагын хичээл явагдах орчин тухайлбал эмнэлзүйн дадлагын хичээлийн орчинд өгсөн сэтгэл ханамжийн дээд утга 3.2, доод утга 2.97, дундаж утга 3.2, суурь шинжлэх ухааны лабораторийн хичээлийн орчинд багш нарын сэтгэл ханамжийн

түвшин дээд утга 3.1, доод утга 2.88, дундаж утга 3.13, онолын семинарын хичээлийн орчинд сэтгэл ханамжийн түвшин дээд утга 3.75, доод утга 3.32, дундаж утга 3.53, ном сурах бичиг гарын авлагын хүртээмжид өгсөн сэтгэл ханамжийн түвшин дээд утга 3.18, доод утга 2.64, дундаж утга 2.91 байлаа (Хүснэгт 6).

Table 6. The level of satisfaction of teachers in the learning environment

Indicator	n	Mean	Std deviation	Std error	Max 95% CI*	Min 95% CI*
Environment of clinical training	77	3,22	1,14	0,25	3,47	2,97
Laboratory classroom environment	77	3,13	1,12	0,25	3,38	2,88
Seminary classroom environment	77	3,53	0,96	0,21	3,75	3,32
Access to books, textbooks and manuals	77	2,91	1,22	0,27	3,18	2,64

Хэлцэмж

Уг судалгаад сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхдээ багш нарын сэтгэл ханамжийн түвшин, бүрэлдэхүүн бүтэц, сэтгэл ханамж, ажлын ачаалал, багшийн ажлын үнэлгээ, сургалтын орчин гэсэн чиглэлүүдэд үндэслэсэн судалгаа болсон нь 2013 онд хийгдсэн Б.Балжинням нарын “Анагаахын хөтөлбөрийн хэрэгжилтэнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа”-аас ялгаатай байлаа. Харин сургалтын орчин материаллаг бааз буюу өрөө тасалгаа анги, танхим, багаж хэрэгсэл хангалтгүй гэсэн үр дүн гарсан нь бидний судалгааны ажлын үр дүнтэй тохирч байна.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд өгсөн багш нарын сэтгэл ханамжийн ерөнхий түвшин дунджаас дээгүүр буюу 4.11 байгаа нь Ж.Оргил нарын Анагаахын суурь сургалтын хөтөлбөрийн үнэлгээ сэдэвт судалгааны ажлын анагаахын суурь сургалтын хөтөлбөрт оюутан багш нарын сэтгэл ханамжийн түвшин дунджаас дээш (3.5) үзүүлэлттэй байна гэсэн үр дүнтэй ойролцоо байна.

Дүгнэлт:

1. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багшлах бүрэлдэхүүний насны бүтцийн хувьд 31-ээс дээш насны багш нар (80%) дийлэнх хувийг эзэлж байгаа ба багшийн албан тушаалын зэрэглэл ажилласан жил нэмэгдэх тутам нэмэгдэж байна. Судалгаанд хамрагдсан багш нарын 68% нь өөрийн зааж буй хичээлийн чиглэлээр мэргэшсэн багш нар байна.
2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн багш нарын сэтгэл ханамжийн ерөнхий түвшин дунджаас дээгүүр буюу 4.11 байгаа боловч, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд нөлөөлөгч хүчин зүйлүүд болох багшийн ажлын үнэлэмж, эмнэлзүйн болон лабораторийн хичээл явуулах сургалтын орчин, ном сурах бичгийн хүртээмжид багш нарын сэтгэл ханамжийн түвшин дунджаас доогуур байна.

Ном зүй:

1. WFME Global Standards in Medical Education-The Trilogy, University of Copenhagen, Denmark, 2001.
2. Tomorrow's Doctors: Recommendations on Undergraduate Medical Education. (1993) Education Committee of the General Medical Council
3. Karle H. Global standards in medical education - an instrument in quality improvement, Journal of Medical Education; 2002. v 36, I 7, p 604.
4. John Dent A and Ronald Harden M. Practical guide for medical teachers, second edition. 2005, p 2-38
5. Отгонбаяр Д. Сургалтын нэгдмэл хөтөлбөрийн үнэлгээний зарим асуудалд. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. Улаанбаатар. 2010.
6. Сүмбэрзул Н., Оюунбилэг Ш. Анагаах ухааны боловсрол. Улаанбаатар 2001. х.68-106.
7. Балжинням Б., Хангай Э., Булгантамир Б., Отгонбаяр Д., Амарсайхан Д. Анагаахын хөтөлбөрийн хэрэгжилтэнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа. Анагаах ухааны боловсрол, УБ, 2013, №5, х. 4-7
8. Оргил Ж., Сэр-Од Х., Түвшинжаргал Ц., Оюунгоо Б. Анагаахын суурь сургалтын хөтөлбөрийн үнэлгээ. Анагаах ухааны боловсрол, УБ, 2018, №7, х. 21-23

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Академич Ц.Лхагвасасүрэн*